

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

### ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төсвийн тухай хуулийн 28<sup>1.5</sup>-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас  
ТОГТООХ нь:

1. “Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд /Б.Жавхлан/, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд /Ч.Хүрэлбаатар/ нарт үүрэг болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

**ТӨСВИЙН ТӨСӨЛ, ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ  
МЭДЭГДЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

**НЭГ.ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

**1.1. Нийтлэг үндэслэл**

- 1.1.1. Монгол Улсын жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөлд иргэдийн байр суурь, үзэл бодлыг тусгах, оролцоог хангах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.1.2. Олон нийтийн хэлэлцүүлгийг /цаашид “хэлэлцүүлэг” гэх/ Төсвийн тухай хуулийн 28<sup>1</sup>.2-т заасны дагуу тухайн жилийн төсвийн төслийг жил бүрийн 8 дугаар сард багтаан, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө тус тус зохион байгуулна.
- 1.1.3. Салбар гэж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23.3-т заасан байнгын хороодын 24-т заасан эрхлэх асуудлын хүрээнд хамаарах салбарыг ойлгоно.
- 1.1.4. Хэлэлцүүлгийн удирдамж гэж хэлэлцүүлгийн тов, хэлбэр, хэлэлцүүлэх асуудал, хэлэлцүүлэг болох огноо, үргэлжлэх хугацаа, хүлээн авах шугам, холбогдох хаягийн мэдээлэл, хэлэлцүүлгийн дэг зэргийг багтаасан баримт бичгийг ойлгоно.

**1.2. Хэлэлцүүлгийн хамрах хүрээ**

- 1.2.1. Жилийн төсвийн төслийн хэлэлцүүлгийг салбаруудаас ирүүлсэн сэдвийн хүрээнд зохион байгуулна.
- 1.2.2. Төсвийн тодотголын төслийн хэлэлцүүлгийг тухайн тодотголын хүрээнд шийдэгдэх асуудлаар зохион байгуулна.

**1.3. Хэлэлцүүлгийн оролцогч талууд**

- 1.3.1. Хэлэлцүүлэг нь зохион байгуулагч, асуудал хэлэлцүүлэгч болон оролцогч талуудаас бүрдэнэ.
- 1.3.2. Хэлэлцүүлгийг зохион байгуулагч гэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон энэ журмын 1.1.3-т заасан салбаруудыг ойлгоно.

1.3.3. Асуудал хэлэлцүүлэгч гэж энэ журмын 1.1.3-т заасан салбаруудыг ойлгоно.

1.3.4. Хэлэлцүүлэгт оролцогч талууд гэж Төсвийн тухай хуулийн 28<sup>1</sup>.2.1-д заасан этгээдийг ойлгоно.

#### **1.4. Хэлэлцүүлэгт оролцогч талуудын эрх, үүрэг**

1.4.1. Хэлэлцүүлэг зохион байгуулагч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

1.4.1.1. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь салбаруудаас ирүүлсэн хэлэлцүүлэх асуудлын сэдвийн саналыг нэгтгэх;

1.4.1.2. хэлэлцүүлгийн удирдамжийг зохион байгуулагч тал боловсруулж, салбарууд руу илгээх;

1.4.1.3. хууль тогтоомжийн тухай хуулийн 38.6-д заасан хэлбэрүүдээс сонгон хэлэлцүүлгийг удирдамжийн дагуу зохион байгуулах;

1.4.1.4. хэлэлцүүлгийг товлосон хугацаанд зохион байгуулна.

1.4.2. Асуудал хэлэлцүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

1.4.2.1. төсвийн тухай хуулийн 8.4.3-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн саналаа нийтэд ил тод мэдээлсний дагуу хэлэлцүүлгийн сэдвийн саналыг олон нийтээс авах;

1.4.2.2. хэлэлцүүлэгт оролцох иргэд, иргэний нийгмийн байгууллагыг урьдчилан бүртгэх;

1.4.2.3. ирсэн сэдвийн саналуудыг эрэмбэлэн ач холбогдол бүхий сэдвийг нэгтгэн, төсвийн саналыг нийтэд ил тод мэдээлснээс хойш 5-аас доошгүй хоногийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр хүргүүлсэн байх;

1.4.2.4. хэлэлцүүлгийн үеэр гарсан тухайн салбартай холбоотой санал, зөвлөмжийг нэгтгэн, төсвийн төсөлд тусгах шаардлагатай саналыг Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасан олон нийтэд ил тод мэдээлсэн төсвийн саналтай нийцүүлж, 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр хүргүүлэх;

1.4.2.5. хэлэлцүүлгийн зохион байгуулалтын зардлыг салбарын тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэнэ.

1.4.3. Хэлэлцүүлэгт оролцогчид нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

1.4.3.1. хэлэлцүүлгийн сэдэвт урьдчилан санал өгөх;

1.4.3.2. хэлэлцүүлэгт биеэр оролцох бол урьдчилан бүртгүүлэх;

1.4.3.3. хууль, журам, удирдамжид заасны дагуу хэлэлцүүлэгт оролцох;

1.4.3.4. хэлэлцүүлгийн сэдвийн хүрээнд санал гаргах бөгөөд тус санал нь Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup>-д заасан шаардлагатай нийцсэн байх;

1.4.3.5. төсвийн төсөлд өгсөн саналууд хэрхэн тусгагдсан талаар мэдээлэл авах.

## **1.5. Саналыг тусгах**

1.5.1. Төсвийн тухай хуулийн 28<sup>1</sup>.2.3-т заасны дагуу зохион байгуулагч тал хэлэлцүүлгээс гарсан эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдол бүхий, зардал бууруулах саналыг дүгнэж, шаардлага хангасан саналыг тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөлд тусгана.

1.5.2. Хөрөнгө оруулалтын саналын тухайд 29<sup>1</sup>.2-т заасан шаардлагыг хангасан саналыг тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөлд тусгана.

1.5.3. Хэлэлцүүлгээс гарсан саналыг төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөлд хэрхэн тусгасан тайлбарыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон нийтэд ил тод мэдээлнэ.

# **ХОЁР.ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙН ТӨСӨЛ, ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

## **2.1. Нийтлэг үндэслэл**

- 2.1.1. Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг тус тус боловсруулахад иргэдийн байр суурь, үзэл бодлыг тусгах, оролцоог хангах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 2.1.2. Олон нийтийн хэлэлцүүлгийг /цаашид “хэлэлцүүлэг” гэх/ Төсвийн тухай хуулийн 28<sup>1.4</sup>-т заасны дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслөөр жил бүрийн 3 дугаар сард багтаан, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд тус тус зохион байгуулна.
- 2.1.3. Хэлэлцүүлгийн удирдамж гэж хэлэлцүүлгийн тов, хэлбэр, хэлэлцүүлэх асуудал, хэлэлцүүлэг болох огноо, үргэлжлэх хугацаа, хүлээн авах шугам, холбогдох хаягийн мэдээлэл, хэлэлцүүлгийн дэг зэргийг багтаасан баримт бичгийг ойлгоно.

## **2.2. Хэлэлцүүлгийн хамрах хүрээ**

- 2.2.1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд туссан асуудлын хүрээнд хэлэлцүүлгийг зохион байгуулна.
- 2.2.2. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн хэлэлцүүлгийг тухайн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд зохион байгуулна.

## **2.3. Хэлэлцүүлгийн оролцогч талууд**

- 2.3.1. Хэлэлцүүлэг нь зохион байгуулагч болон оролцогч талуудаас тус тус бүрдэнэ.
- 2.3.2. Хэлэлцүүлгийг зохион байгуулагч гэж эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг ойлгоно.
- 2.3.3. Хэлэлцүүлэгт оролцогч талууд гэж Төсвийн тухай хуулийн 28<sup>1.2.1</sup>-д заасан этгээдийг ойлгоно.

## **2.4. Хэлэлцүүлэгт оролцогч талуудын эрх, үүрэг**

2.4.1. Хэлэлцүүлэг зохион байгуулагч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

- 2.4.1.1. хэлэлцэх асуудлын сэдвийг гаргах;
- 2.4.1.2. хэлэлцүүлгийн удирдамжийг боловсруулах;
- 2.4.1.3. Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.6-д заасан хэлбэрүүдээс сонгон хэлэлцүүлгийг удирдамжийн дагуу зохион байгуулах;
- 2.4.1.4. хэлэлцүүлгийг товлосон хугацаанд зохион байгуулах;
- 2.4.1.5. хэлэлцүүлэгт оролцох иргэд, иргэний нийгмийн байгууллагын жагсаалтыг урьдчилан бүртгэх;

2.4.2. Хэлэлцүүлэгт оролцогчид нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

- 2.4.2.1. хэлэлцүүлэгт биеэр оролцох бол урьдчилан бүртгүүлэх;
- 2.4.2.2. хууль, журам, удирдамжид заасны дагуу хэлэлцүүлэгт оролцох;
- 2.4.2.3. хэлэлцүүлгийн сэдвийн хүрээнд санал гаргах;
- 2.4.2.4. дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн саналууд хэрхэн тусгагдсан талаар мэдээлэл авах.

## **2.5. Саналыг тусгах**

2.5.1. Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэлэлцүүлгээс гарсан саналыг дүгнэж, үндэслэл бүхий тооцоо судалгаатай саналыг төсвийн нөөц боломжтой уялдуулан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд тусгана.

2.5.2. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд олон нийтийн саналыг хэрхэн тусгасан тайлбарыг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэлэлцүүлэг болсноос хойш 7-оос доошгүй хоногт багтаан нийтэд ил тод мэдээлнэ.





## ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

1. Хэлэлцүүлгийн хэлбэр
2. Хэлэлцүүлэг болох байршил болон ашиглах мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслийг тодорхой заана. Мэдээлэл, харилцаа холбооны дараах хэрэгслүүд байна. Үүнд:
  - 1.1. Захидал
  - 1.2. Утас
  - 1.3. Цахим шуудан
  - 1.4. Цахим хуудас
  - 1.5. Аппликейшн
  - 1.6. ...
3. Хугацаа
  - 3.1. Эхлэх хугацаа
  - 3.2. Дуусах хугацаа
4. Хэлэлцүүлгийн дэг
  - 4.1. Хэлэлцүүлгийг танхимын хэлбэрээр зохион байгуулах үед:
    - 4.1.1. Зохион байгуулагч нь хэлэлцүүлгийн сэдэв, хамрах хүрээ болон хэлэлцүүлэгт оролцогч талуудыг танилцуулж, хэлэлцүүлгийг эхлүүлнэ.
    - 4.1.2. Хэлэлцүүлэгт оролцогчийн санал хэлэх хугацаа 3-5 минутаас илүүгүй байна.
    - 4.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд саналаа А-4 хэмжээний нэг цаасанд багтаан урьдчилан бэлтгэж, зохион байгуулагчид өгч уншуулна.
    - 4.1.4. Хэлэлцүүлэгт оролцогч бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, яриаг нь таслах зэрэг бусдын үгээ чөлөөтэй хэлэхэд нь саад учруулсан үйлдэл гаргавал хэлэлцүүлэг хөтлөгч дэг баримтлахыг шаардах бөгөөд шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд зохион байгуулагчид оролцогчийг танхимаас гаргана.
  - 4.2. Хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр зохион байгуулах үед:
    - 4.2.1. Оролцогчид нь зохион байгуулагчийн цахим талбарт байршуулсан хэлэлцүүлгийн сэдвийн дор хэлэлцүүлгийн хүрээнд саналаа ирүүлнэ.
    - 4.2.2. Цахим хэлэлцүүлгийн заасан хугацаанд саналаа хүргүүлнэ.